“САНХҮҮЧ-АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ИЛЛАНАЙ ББСБ” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид

Дүгнэлт

Бид 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бусад хураангуйг багтаасан санхүүгийн тэмдэглэлээс бүрдсэн “ИЛЛАНАЙ ББСБ” ХХК (“Компани” гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар компанийн 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁЗСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу компаниас хараат бус болно. Бид НБОУЁЗСЗ-ийн болон МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлагын хүлээх Үүрэг, Хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан, эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

“Санхүүч-Аудит” ХХК,
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо. Нарны зам, Шинэ тэрэг плаза.
Утас/Факс: +976 77116177, 91916177 Е-мэйл: info@sankhuuch-audit.mn

САНХҮҮЧ-АУДИТ ХХК

Санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь Байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. Санхүүгийн тайлангийн аудитад хүлээсэн аудиторын үүрэг хариуцлагын талаарх тус компанийн тодорхойлолт нь манай аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

“САНХҮҮЧ-АУДИТ” ХХК

Захирал Б.Алтантуяа

Монгол улс, Улаанбаатар хот.

2023 оны 02-р сарын 06-ны өдөр

"ИЛЛАНАЙ ББСБ" ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	2021.12.31	2022.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	*6*	571,844,605.9	59,487,893.5
Зээл /цэвэр/	*7*	8,676,145,341.7	14,259,851,009.8
Бусад авлага	*8*	901,256,574.7	535,636,667.7
Эргэлтийн хөрөнгийн дүн		**10,149,246,522.3**	**14,854,975,570.9**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө /цэвэр/	*9*	11,818,670.7	6,800,492.7
Биет бус хөрөнгө	*10*	2,330,717.0	5,550,142.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**14,149,387.7**	**12,350,634.7**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**10,163,395,910.0**	**14,867,326,205.6**
ӨР ТӨЛБӨР			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Бусад өр төлбөр	*11*	68,386,255.4	143,374,023.5
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**68,386,255.4**	**143,374,023.5**
Урт хугацаат зээл	*12*		2,510,000,000.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн			**2,510,000,000.0**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		**68,386,255.4**	**2,653,374,023.5**
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Энгийн хувьцаа	*13*	3,400,000,000.0	3,400,000,000.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		6,671,394,422.9	8,790,336,950.5
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		23,615,231.7	23,615,231.7
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН		**10,095,009,654.6**	**12,213,952,182.2**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		**10,163,395,910.0**	**14,867,326,205.6**

Энэхүү санхүүгийн тайлангийн 9-19 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь эдгээр тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮЧ-АУДИТ ХХК

“ИЛЛАНАЙ ББСБ” ХХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	2021.12.31	2022.12.31
Хүүний орлого	*14*	1,272,151,779.5	2,274,650,991.2
Хүүний зардал		-	-
Цэвэр хүүний орлого		**1,272,151,779.5**	**2,274,650,991.2**
Хүүний бус орлого	*15*	73,544,412.7	83,159,389.7
Хүүний бус зардал	*16*	121,900,839.4	122,891,491.2
Цэвэр хүүний бус орлого/зардлын дүн		(48,356,426.7)	(39,732,101.5)
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал		**1,223,795,352.8**	**2,234,918,889.7**
Болзошгүй эрсдлийн зардал		-	-
Үндсэн үйл ажилагааны ашиг/алдагдал		**1,223,795,352.8**	**2,234,918,889.7**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	*17*	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	*18*	4,353,445.0	2,820,700.0
Ердийн үйл ажилагааны ашиг/алдагдал		**1,219,441,907.8**	**2,232,098,189.7**
Татварын өмнөх ашиг /алдагдал		**1,219,441,907.8**	**2,232,098,189.7**
Орлогын татварын зардал	*19*	122,595,807.7	223,491,889.0
Цэвэр ашиг /алдагдал		**1,096,846,100.1**	**2,008,606,300.7**

Энэхүү санхүүгийн тайлангийн 9-19 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь эдгээр тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮЧ-АУДИТ ХХК

“ИЛЛАНАЙ ББСБ” ХХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020.12.31-ний үлдэгдэл	**1,400,000,000.0**	**18,528,403.7**	7,796,770,545.0	**9,215,298,948.7**
Дахин үнэлгээний өсөлт, бууралт		5,086,828.0		**5,086,828.0**
Тайлант үеийн цэвэр ашиг			1,096,846,100.1	**1,096,846,100.1**
Хувьцаат капиталын өсөлт	2,000,000,000.0		(2,222,222,222.2)	**(222,222,222.2)**
2021.12.31-ний үлдэгдэл	**3,400,000,000.0**	**23,615,231.7**	**6,671,394,422.9**	**10,095,009,654.6**
ОДТ-нд зөвшөөрөөгүй олз*		-	110,336,226.9	**110,336,226.9**
Тайлант үеийн цэвэр ашиг			2,008,606,300.7	**2,008,606,300.7**
2022.12.31-ний үлдэгдэл	**3,400,000,000.0**	**23,615,231.7**	**8,790,336,950.5**	**12,213,952,182.2**

**2021 оны ОАТ-ын зардлын 90 хувийн буцаалт*

Энэхүү санхүүгийн тайлангийн 9-19 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь эдгээр тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮ-АУДИТ ХХК

"ИЛЛАНАЙ ББСБ" ХХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭ	**(424,437,958.1)**	**(3,019,536,012.4)**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**7,322,624,365.3**	**7,206,847,460.7**
Зээлийн хүүний орлого	1,169,057,540.9	1,938,143,389.5
Зээлийн эргэн төлөлт	6,118,571,496.7	4,401,354,906.5
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	32,672,280.0	46,563,016.6
Бусад үйлчилгээний орлого	2,323,047.7	820,786,148.1
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**7,747,062,323.4**	**10,226,383,473.1**
Зээл олголт	6,645,153,000.0	9,957,964,000.0
Үндсэн ба нэмэгдэл цалин	41,622,409.0	47,239,965.1
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	12,135,400.0	14,794,300.0
Албан томилолт, сургалтын зардалд төлсөн	120,000.0	720,000.0
Шатахуун, холбоо, интернет, сэлбэгд төлсөн мөнгө	3,219,996.4	3,702,814.8
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	2,669,810.0	1,642,940.0
Татвар, даатгалд төлсөн мөнгө	283,280,741.3	154,838,198.8
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	1,700,000.0	-
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөөний үйлчилгээнд төлсөн	14,424,528.0	10,181,347.8
Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарсан	-	33,000,000.0
Зээл, авлагыг барагдуулахтай холбоотой гарсан	430,000.0	-
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	700,000,000.0	-
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	42,306,438.7	2,299,906.7
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(4,301,800.0)**	**2,507,179,300.0**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**-**	**2,510,000,000.0**
Бусад	-	2,510,000,000.0
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**4,301,800.0**	**2,820,700.0**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	4,301,800.0	2,820,700.0
Бусад	-	-
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(428,739,758.1)**	**(512,356,712.4)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**1,000,584,363.9**	**571,844,605.9**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**571,844,605.9**	**59,487,893.5**

Энэхүү санхүүгийн тайлангийн 9-19 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь эдгээр тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮЧ-АУДИТ ХХК